



## БАЯНХОНГОР АЙМАГТ 2022 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2023 оны 01 дүгээр сарын 05

Номгон

### НЭГ: ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

1.1. Тус цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 5263 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 747 буюу 16.5 хувиар өссөн. Үүнээс 1273 буюу 24.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3990 буюу 75.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол,  
мэдээллийн шийдвэрлэлт :

Зөрчлийн шинжтэй гомдол,  
мэдээллийн шийдвэрлэлт:




Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 110 буюу 8.6 хувийг 5 хоногт, 1118 буюу 87.8 хувийг 6-19 хоногт, Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 3898 буюу 97.7 хувийг 5 хоногт тус тус шалгаж шийдвэрлэсэн.

Хүлээн авч шалгасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 38, зөрчлийн шинжтэй 35 нийт 73 буюу 5.7 хувь нь шийдвэрлэгдээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

### ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд энэ онд 439 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11 нэгжээр буюу 18.4 хувиар өссөн.



Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 254 хэрэг бүртгэгдснээс 131 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 51.6 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5.1 пунктээр буурсан байна.


**59.9%**

**40%**


**263** нь Баянхонгор сум  
буюу **176** нь бусад сумдад  
Баянхонгор сум



**Гэмт хэргийн гаралтыг багаар нь харьцуулсан байдал**




**Гэмт хэргийн гаралтыг сумдаар нь харьцуулсан байдал**



### Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 366 буюу 83.3 хувь нь хөнгөн ангилалын, 73 буюу 16.6 хувь нь хүнд ангилалын гэмт хэрэг бүртгэгдсэн.



### Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:


Хэргийн ангилал	Өссөн дүнгээр			
	2021 он	2022 он	Өөрчлөлт	
			Өөрчлөлт	Хувь
Хүнийг алах	3	4	1	33.3%
Хүнийг амиа хорлох нөхцөл, байдалд хүргэх	2	2		
Хүний эрүүл мэндийн халдашгүй байлын эсрэг	179	146	-33	-18.4%
Хүчиндэх	16	11	-5	-31.2%
Хулгайлах	67	78	11	16.4%
Илгээ хулгайлах	21	33	12	57.1%
Дээрэм	4	2	-2	-50%
Залилах	38	83	45	1.1 дахин
Хүрээлэн буй орчны эсрэг	27	15	-12	-44.4%
Бусад	19	27	8	42.1%

### Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:



- Өмчлөх эрхийн эсрэг
  - Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг
  - Бусад
- Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:**


Бүртгэгдсэн гэмт хэргийн 122 буюу 27.7 хувь нь согтуугаар, 36 буюу 8.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 53 буюу 12 хувь нь бүлэглэн, 41 буюу 9.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.




## Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн газар, гараг, цаг хугацаа

Баянхонгор аймагт бүртгэгдсэн 439 гэмт хэргээс 127 буюу 28.9 хувь нь гэр орон сууцанд, 48 буюу 10.9 хувь нь гудамж талбайд, 34 буюу 7.7 хувь нь олон нийтийн газар, 27 буюу 6.1 хувь нь авто замд, 7 буюу 1.5 хувь нь төрийн байгууллага, 12 буюу 3.4 хувь нь аж ахуйн нэгжид, 182 буюу 41.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн гараг:




Үйлдэгдсэн цаг:




## Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 443 иргэн хохирч, үүнээс 173 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 23 нэгжээр буюу 11.7 хувиар буурч, 17 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 нэгжээр буюу 21.4 хувиар өссөн байна.




Гэмт хэргийн улмаас 2010.0 сая төгрөгийн хохирол учирснаас 442.0 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 21.9 хувьтай байна.



## Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 380 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 нэгжээр буюу 2.8 хувиар буурсан бөгөөд 33 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь 26.6 хувиар буурч, 107 хүн урьд ял шийтгэгдсэн нь 13.8 хувиар өссөн.



### ГУРАВ: ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

Аймгийн хэмжээнд 2022 оны 12 дугаар сард нийт 22348 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4626 зөрчлөөр буюу 26.1 хувиар өссөн. Бүртгэгдсэн зөрчлийн 22263 буюу 99.6 хувийг шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлөөс **19426** зөрчлийг ердийн журмаар **502727.8** төгрөгөөр, **1989** зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар



### Нийгмийн байдал




### Боловсролоор нь



**547335.0** мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан **161** өрчлийг **36105.0** мянган төгрөгөөр /нийт торгууль **1.086167.3/** тус тус торгож шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд 667 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь **105** нэгжээр буюу **+18.7** хувиар, **862** зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **25** нэгжээр буюу **2.5** хувиар өссөн байна.



### Зөрчил үйлдэгдсэн онцлог:


Зөрчил үйлдэгдсэн байдал	2021.12 сар	2022.12 сар	/Өсөлт,бууралт/	Хувиар
Согтуугаар	1833	1928	95	5.1%
Хүүхэд оролцсон	19	25	6	31.6%
Эмэгтэй хүн оролцсон	280	448	168	60%
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	206	283	77	37.4%
Олон нийтийн газар	98	109	11	11.2%
Гэр орон сууцанд	548	619	71	13%
Гудамж талбайд	1868	1885	17	0.9%

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилтэй харьцуулсан эзлэх хувь:

Зөрчил гарсан цагаар нь:		Зөрчил гарсан өдрөөр нь:	
06-12 цагт	4748 буюу 26.8%	Даваа гараг	2763 буюу 15.6%
		Мягмар гараг	2820 буюу 15.9%
13-18 цагт	8031 буюу 45.3%	Лхагва гараг	2737 буюу 15.4%
		Пүрэв гараг	2834 буюу 16%
19-24 цагт	4146 буюу 23.4%	Баасан гараг	2745 буюу 15.4%
		Бямба гараг	2026 буюу 11.4%
01-05 цагт	797 буюу 4.5%	Ням гараг	1797 буюу 10.1%

### Зөрчил үйлдсэн иргэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл:

Энэ хугацаанд 2833 иргэн зөрчилд холбогдон шалгагдсанаас 533 буюу 18.8 хувь нь эмэгтэй, 806 буюу 28.4 хувь нь малчин, 584 буюу 20.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 218 буюу 7.7 хувь нь төрийн албан хаагч эзэлж байгаа нь бусад салбараас өндөр хувийг эзэлж байна.



Шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтнаар нь авч үзвэл:



2076 буюу **73.3** хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч




672 буюу **26.7** хувьд шүүгч

Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх, саатуулах үйл ажиллагаа:

Энэ хугацаанд 555 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 289 нэгжээр буюу 34.2 хувиар буурч, эрүүлжүүлэгдсэн хүний 415 буюу 74.7 хувийг гэр, орон сууцнаас, 99 буюу 17.8 хувийг гудамж талбайгаас, 18 буюу 3.2 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 7 буюу 1.3 хувийг үзвэр, үйлчилгээний газраас, 2 буюу 0.4 хувийг зочид буудлаас, 9 буюу 1.6 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 524 буюу 94.4 хувь нь эрэгтэй, 31 буюу 30.6 хувь нь эмэгтэй хүн эзэлж байна.

**НЭГ: ДҮГНЭЛТ**

Аймгийн хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

**НЭГ. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТАЛААР:**

1.1. Тус цагдаагийн газарт 2022 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 5263 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 747 нэгжээр буюу 16.5 хувиар өссөн.

1.2 Баянхонгор аймгийн Цагдаагийн газар нь нийт хүлээн авч шалгасан гомдол, мэдээллийн ачааллаар орон нутгийн хэмжээнд ДӨРӨВДҮГЭЭРТ эрэмбэлэгдэж байна.

### **ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР:**

2.1. Энэ хугацаанд нийт 439 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 нэгжээр буюу 18.4 хувиар өссөн.

2.2. Бүртгэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг Эрүүгийн хуулийн бүлгээр нь авч үзвэл: хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 146 бүртгэгдэж 18.4 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 11 бүртгэгдэж 31.2 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 2 бүртгэгдэж 50 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 15 бүртгэгдэж 44.4 хувиар тус тус **буурч**, хүнийг алах гэмт хэрэг 4 бүртгэгдэж 33.3 хувиар, хулгайлах гэмт хэрэг 78 бүртгэгдэж 16.4 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 33 бүртгэгдэж, 57.1 хувиар, залилах гэмт хэрэг 83 бүртгэгдэж 1.1 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 27 бүртгэгдэж 42.1 хувиар тус тус **өссөн**.

2.3. Бүртгэгдсэн хэргийн 146 буюу 33.2 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 218 буюу 49.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 82.9 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 59.9 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдэж 10 хувиар өсч, 31.1 хувь нь бусад сумдад үйлдэгдэж 13 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн зонхилон үйлдэгддэг хулгайлах, мал хулгайлах, залилах болон бусад гэмт хэргүүд өссөн нь нийт хэрэг өсөхөд нөлөөлсөн.

2.4. Залилах гэмт хэрэг 1.1 дахин өссөн . Тэр дундаа залилах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь онцгой анхаарал татаж байна.

### **ГУРАВ. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ТАЛААР:**

3.1. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 51.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.1 хувиар буурсан нь цаашид гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

### **ДӨРӨВ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД ХОЛБОГДОГЧИЙН ТАЛААР:**

4.1. Гэмт хэрэгт холбогдогчдийн 67 буюу 17.6 хувь нь насанд хүрээгүй хүн байна.

Мөн төрийн албан хаагчдаас гэмт хэрэг, зөрчилд холбогдох явдал нь таслан зогсоогдохгүй байгаа тул шийдвэрлэгдсэн тухай бүр нь байгууллагад нь “Албан мэдэгдэл” хүргүүлж, үр дүнг нь тооцож ажиллаж, сахилга ёс зүйг нь сайжруулах шаардлагатай байна.

### **ТАВ. ЗӨРЧЛИЙН ТАЛААР:**

5.1. Аймгийн хэмжээнд 2022 онд нийт 22348 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4626 зөрчлөөр буюу 26.1 хувиар өссөн Зөрчил гаргасан нийт 21576 иргэнийг торгууль 1.086167.3 төгрөгөөр торгосон. Үүнээс 18294 буюу 84.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчил байна.



5.2. Энэ хугацаанд 555 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 289 нэгжээр буюу 34.2 хувиар буурч, эрүүлжүүлэгдсэн хүний 415 буюу 74.7 хувийг гэр, орон сууцнаас, 99 буюу 17.8хувийг гудамж талбайгаас, 18 буюу 3.2 хувийг байгууллага, аж ахуйн нэгжээс, 7 буюу 1.3 хувийг үзвэр, үйлчилгээний газраас, 2 буюу 0.4 хувийг зочид буудлаас, 9 буюу 1.6 хувийг бар цэнгээний газраас тус тус эрүүлжүүлэгдсэн байна.

### **САНАЛ**

1. Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сайн хөрш”-хөршийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, чадавхжуулах сургалт зохион байгуулах
2. Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Баянхонгор сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран гудамж талбайн гэрэлтүүлэг, камерын хяналтыг сайжруулах
3. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэмт хэргийн гаралт өсөлттэй бай
4. гаа сумдын ГХУСАЗСЗ-тэй хамтран ажиллах, тус зөвлөлүүдэд танилцуулга хүргүүлэх,
5. Цахим орчинд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк бүлгэмүүдийг ашиглан мэдээллийг тасралтгүй түгээх,
6. Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах,
7. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах, сургалт мэдээллийг тогтмол зохион байгуулах

МЭДЭЭ ГАРГАСАН:

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Б.БЯМБАА

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:

ДАРГА,

ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.МӨНХБАЯР